

## **Усны холбогдолтой хууль тогтоомжуудын талаарх судалгаа**

### **1. Судалгааны тухай**

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудаас усны холбогдолтой хууль тогтоомжуудын жагсаалт, зүйл заалтуудыг 2004 оны “Усны тухай” хуультай харьцуулах байдлаар энэхүү бичил судалгааг хийлээ.

### **2. Судалгааны зорилго**

Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын усны салбартай холбоотой зохицуулалтуудын уялдаа холбоог тодорхойлох, хууль тогтоомжуудын хэрэгжилтийн байдал, үр дүнд дүн шинжилгээ хийх, усны болон байгаль орчны салбарт ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд, иргэд хувийн хэвшлийн байгууллагуудад энэ салбарын эрх зүйн зохицуулалтын талаар нэгдсэн ойлголт өгөх, хуулийг нэгдсэн байдлаар хэрэглэхэд энэхүү судалгааны зорилго оршино.

### **3. Судалгааны хүрээ, судалгаа арга**

Энэхүү судалгаанд зөвхөн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудаас ус, усан орчин, түүнийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлууд, усны асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын эрх үүрэгтэй холбоотой хуулийн заалтууд хамрагдсан бөгөөд хуулийн дагуу гарах ёстой бүх нийтээр дагаж мөрдөх болон бусад дүрэм, журам судалгааны дараагийн үе шатанд хамрагдах болно. Судалгаа нь хэрэгжиж буй хууль тогтоомжуудын уялдаа холбоог энгийн харьцуулалтын аргаар тодорхойлох замаар хийгдсэн болно.

### **4. Судалгааны ажлын агуулга**

Судалгааны ажил нь дараах агуулгатай байна. Үүнд:

- Усны салбарын харилцааг зохицуулахаар гаргасан хууль тогтоомжийн жагсаалт
- Жагсаалтанд орсон хууль тогтоомжуудын агуулга, онцлогийг тусгасан товч танилцуулга хууль тус бүр дээр
- Ус, усны нөөц, усны хэрэглээтэй холбоотой асуудлуудаар УИХ, Засгийн газраас баталсан хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийн жагсаалт
- Усны асуудлаар Монгол улсын нэгдэс орсон олон улсын гэрээ хэлэлцээрүүд

**Нэг. Усны салбарын харилцааг зохицуулахаар гаргасан хууль тогтоомжийн жагсаалт**

1. Үндсэн хууль
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
4. Ус рашаан ашигласаны төлбөрийн тухай
5. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай
6. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай
7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай
8. Ариун цэврийн тухай
9. Далай ашиглах тухай
10. Хүнсний тухай
11. Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах хувь хэмжээний тухай хууль
12. Хот суурины ус хангамж, ариутгах татварын ашиглалтын тухай
13. Рашааны тухай
14. Усан замын тээврийн тухай
15. Усны тухай
16. Татварын ерөнхий хууль

**Хоёр. Усны Хэрэг Эрхлэх Газрын үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэглэгдэх хууль тогтоомжийн жагсаалт**

1. Үндсэн хууль
2. Засгийн газрын тухай
3. УИХ-ын тухай хууль
4. Хилийн тухай
5. Агаарын тухай
6. Ойн тухай
7. Байгалийн ургамлын тухай
8. Химийн хорт бодисоос хамгаалах тухай
9. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай
10. Төрийн нууцын тухай
11. Хувь хүний нууцын тухай
12. Байгууллагын нууцын тухай
13. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласаны төлбөрийн тухай
14. Байгалийн ургамал ашигласаны төлбөрийн тухай
15. Агнуурын нөөц ашигласаны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай
16. Ургамал хамгааллын тухай
17. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
18. Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай
19. Ашигт малтмалын тухай
20. Геодези, зураг зүйн тухай

21. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай
22. Амьтны аймгийн тухай, ан агнуурын тухай
23. Нягтлан бодох бүртгэлийн тухай
24. Газрын тухай
25. Төрийн албаны тухай
26. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай
27. Төрийн хяналт, шалгалтын тухай
28. Төрийн аудитын тухай
29. Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай
30. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай
31. Тариалангийн тухай
32. Засгийн газрын тусгай сангийн тухай

**Гурав. Жагсаалтанд орсон хууль тогтоомжуудын агуулга, онцлогийг тусгасан товч танилцуулга**

1. **Үндсэн хууль** /Монгол улсын төрийн байгууламжийн ерөнхий бүтэц, засаглалын хэлбэрийг тодорхойлон, хүний эрх, эрх чөлөөг хуульчлан заасан бөгөөд Монгол улсын иргэн “эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” хэмээн байгаль орчны эрх зүйн үндсийг тодорхойлсон.1992 он/
2. **Байгаль орчныг хамгаалах тухай хууль** /Байгаль орчны эрх зүйн тулгуур хууль бөгөөд байгаль орчны эрх зүйн объектуудын эрх зүйн үүднээс тодорхойлон заасан. Тухайлбал: байгаль орчны эрх зүйн объект нь газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар хэмээн тодорхойлсон ба хууль ёсоор ус гэдэгт “Монгол улсын нутан дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорх ус хамаарна” гэж тодорхойлсон. Мөн байгаль орчныг хамгаалах талаар төр, төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаа түүний зарчмуудыг тодорхойлон, байгалийн баялагийг өмчлөх, эзэмших, ашиглах харилцааны субъектууд, тэдгээрийн эрх үүрэг, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх журмыг заасан болно. 1995 он/
3. **Усны тухай хууль** /Ус, түүний сав газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдон үүсэх нийгмийн бүхий л харилцааг зохицуулах бөгөөд энэ хүрээнд усны салбарт үйл ажиллагаа явуулах төрийн байгууллагуудын эрх үүрэг, ажил үүргийн хуваарилалтыг хуульчлан тогтоосон. Хуульд зааснаар усны асуудал эрхэлсэн байгууллагууд нь байгаль орчны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд ажиллах болсон нь экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлж, байгаль орчны тэнцлийг хангах хуулийн зарчмыг хэрэгжүүлж буй хэрэг юм. Тухайлбал: усны асуудал эрхэлсэн засгийн газрын эрх бүхий байгууллага, гол мөрний сав газрын зөвлөлийг төрийн байгууллагын тогтолцоонд суулгасан. Мөн ус ашиглалтын байдалд хяналт тавих зорилгоор ус хэрэглэгч, ус ашиглагч гэсэн эрх зүйн ойлголтыг шинээр бий болгон ус

ашиглагч нь усны нөөц ашигласаны төлбөрийг мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтийн дагуу төлөх тогтолцоог бий болгож, усны асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд нь мэргэжлийн дүгнэлт гаргах замаар усны нөөцийн ашиглалтанд урьдчилсан хяналт тавих болсон. Усны асуудал хариуцсан засгийн газрын эрх бүхий байгууллага усны нөөцийн ашиглалтанд мэргэжлийн дүгнэлтээр дамжуулан урьдчилсан хяналт тавих болсноор усны салбарын бүхий л үйл ажиллагаанд оролцох, төрийн бусад байгууллага, яамд агентлагуудтай усны асуудлаар харилцах эрх нь нээгдсэн болно./

4. **Ус рашаан ашигласаны төлбөрийн тухай хууль** /Энэхүү хууль нь 1992 онд батлагдаж 2001 онд нэмэлт өөрчлөлт орсон Татварын ерөнхий хуулийн “ус рашаан ашигласаны төлбөр нь орон нутгийн татварт хамаарагдана.” гэж 17-р зүйлд заасны дагуу татварын багц хуулийн хүрээнд батлагдсан. Энэ хуулийн 2-р зүйлд ус рашаан ашигласаны төлбөрийн тухай хууль тогтоомж нь татварын ерөнхий хууль, усны тухай хууль, энэ хууль, түүнтэй зохицуулан гаргасан бусад хууль тогтоомжноос бүрдэнэ гэж заажээ. Энэхүү хуулиар ус, рашаан ашиглагчдын төлбөр ноогдох зүйлийг тодорхойлж (*1/хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус; 2/эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан; 3/эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин; 4/уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус*) төлбөр төлөх үзүүлэлт болон төлбөрийн хувь хэмжээний дээд доод хязгаарыг тогтоосон ба ус ашигласаны төлбөрийн хэмжээг энэ хуулийн хязгаарт нийцүүлэн Засгийн газар, рашаан ашигласны төлбөрийг ИТХ тогтоохоох хуульчилсан байна. Хуулийн төлбөр ногдуулах, тайлагнах журам нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тайлагнах журамтай ижилхэн байгаа нь 2004 онд батлагдсан “Усны тухай” хуулийн үзэл санаа, мэргэжлийн дүгнэлт гаргах асуудалтай зөрчилдөж байгаа юм/
5. **Рашааны тухай хууль** /Энэхүү хууль Монгол улсын эрх зүйн тогтолцоонд бие даасан байр суурьтай байгаа нь “рашааны тухай хууль тогтоомж нь үндсэн хууль, энэ хууль эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжноос бүрдэнэ” гэсэн 2-р зүйлээс харагдаж байна. Хуульд рагааны асуудлаар төрийн захиргааны төв байгууллагууд тэр дундаа эрүүл мэндийн болон, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын эрх үүргийг яг ижил байдлаар тодорхойлсон (хуулийн 6-р зүйл) рашаан ашиглах зөвшөөрлийг усны тухай болон тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохицуулна гэж заасан нь УХЭГ-аас рашааны асуудлаар ч мэргэжлийн дүгнэлтээр дамжуулан бодлогоо хэрэгжүүлэх боломжийг олгож байгаа юм./
6. **Хот суурины ус хангамж, ариутгах татварын ашиглалтын тухай хууль** /Энэ хууль нь хот суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэргэлээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг ашиглахтай холбогдсон эрх харилцааг зохицуулдаг ба “цэвэр усыг ахуйн болон үйлдвэрлэлтийн зориулалтаар ашиглах асуудлыг усны тухай хуулиар

зохицуулна” (хуулийн 2.2-р зүйл) хэмээн усны тухай хууль, түүгээр дамжуулан усны салбарын байгууллагуудын эрх үүргийг тодорхойлсон байна. 1995 онд энэ хууль батлагдахдаа ариутгах татуургын асуудал хариуцсан засгийн газрын эрх бүхий байгууллага байхаар зохицуулдсан байсан боловч 2004 онд Усны тухай хуулиар усны асуудал эрхэлсэн засгийн газрын эрх бүхий байгууллага байгуулагдсантайгаар холбогдуулан энэ хэсгийг буюу хуулийн 5-р зүйлийг хүчингүй болгосон байна. Энэ хуульд цэвэр усны үнэ, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг тогтоох аргачлал, усны тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн усны хэмжээг тогтоох хэрэглээний хэмжээ норм зэргийг байгаль орчны болон барилга хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлахаар тогтоожээ. /

7. **Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль** /1994 онд батлагдсан энэ хууль нь байгалийн бүс бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгыг тусгай хамгаалалтанд авах, ашиглах, түний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой бөгөөд аливаа уст цэг, усны эх үүсвэр, гол мөрнийг тусгай хамгаалалтанд авсан тохиолдолд энэ хуулийг дагаж мөрдөнө. /
8. **Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай** /Тусгай хамгаалалттай газар нутагийг хамгаалах зорилгоор ТХГН-ын орчны бүсийг тогтоох асуудлыг зохицуулсан ба энэхүү орчны бүсэд уст цэг, усны эх үүсвэр, гол мөрөн хамрагдсан тохиолдолд энэ хуулийг дагаж мөрдөнө. /
9. **Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай** /Ус, цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд гадаргын усны мэдээллээр усны асуудал эрхэлсэн байгууллагыг хангах үүрэгтэй байна. /
10. **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай** /Энэ хууль байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцэл алдагдахаас сэргийлэх, байгалийн баялагийн ашиглалтыг зохицуулах, төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, төслийг хэрэгжүүлэх эсэх талаар шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд энэ нь ус ашиглуулах мэргэжлийн дүгнэлт гаргах ажилтай салшгүй холбоотой байна. /
11. **Ариун цэврийн тухай** / Хуулийн 5-р зүйлд “5.1. Хүн амын унд, ахуйд ашиглаж байгаа усны эх булаг, ус түгээгүүрийн шугам сүлжээ, ус нөөцлөх сан, шахуургын станц, ус түгээх байранд холбогдох дүрмийн дагуу хамгаалалтын бүс тогтоож, бохирдолтоос хамгаалах арга хэмжээг нутгийн захиргааны болон ус ашиглалтын байгууллага, аж ахуйн нэгж, иргэн авч хэрэгжүүлнэ. 5.2. Хүн амын унд, ахуйд түгээж байгаа усны чанарт ус ашиглалтын байгууллагаас стандарт, дүрмийн дагуу үйлдвэрлэлийн хяналт, шинжилгээ хийж, усны чанарыг сайжруулах арга хэмжээ авна.” гэж заасан нь энэ хууль усны тухай хуулийг хамтад хэрэгжүүлэх шаардлагатай болохыг харуулж байна. /

12. **Далай ашиглах тухай** /Энэхүү хууль нь Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далайн баялаг олборлох, загас агнах, тээвэр хийх зэрэг далай ашиглах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохиужжлах зорилготой ба загас агнах үйл ажиллагааг УХЭГ хариуцах тохиолдолд энэ хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай/
13. **Хүнсний тухай** /Энэ хуулиар хүн амыг хүнсээр хангах, хүнс, хүнсний аюулгүй байдалтай холбоотой харилцааны зохицуулалтыг тусгасан ба ундны усыг стратегийн хүнс хэмээн тохдорхойлжээ. (хуулийн 3.1.6-р зүйл) Мөн хүн амын цэвэр усны хангамжийн зорилгоор “5.1.2 хүн амын ундны усны эрэл хайгуул хийх, усны нөөц, уст цэгийг нэмэгдүүлэх, ус цэнгэгжүүлэх бодолго боловсруулж, хэрэгжүүлэх, 5.1.4 хүн амын ундны эх үүсвэр, усан хангамжийн байгууламжийг хамгаалалтанд байлгах, түүнд хяналт тавих журам тогтоох” асуудлыг Засгийн газарт хариуцуулсан байна./
14. **Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах хувь хэмжээний тухай хууль** /Энэ хууль нь байгалийн баялагийг ашигласаны төлбөрийн орлогоор цугларсан хөрөнгийг хэрхэн хуваарилах асуудлыг зохицуулсан бөгөөд усны төлбөрөөс улсын төсөвт төвлөрсөн хөрөнгөний 35 хувийг усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах тухай заасан байна. /
15. **Усан замын тээврийн тухай** /Энэхүү хууль нь усан замаар төрөл бүрийн тээвэр хийх асуудлыг зохицуулахдаа тээвэрлэгч нь ус, усан орчинг хамгаалах, нөхөн сэргээх үүрэгтэй байна гэдэг зарчмыг баримталсан байна. Хуульд усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байхаар заасан байна./
16. **Татварын ерөнхий хууль** /1992 онд батлагдсан татварын ерөнхий хуульд татвар нь албан татвар, хураамж, төлбөр гэсэн 3 хэсгээс бүрдэх ба татварын хэмжээг хэн тогтоож, хаана төвлөрүүлж байгаагаас нь шалтгаалж улсын татвар, орон нутгийн татвар гэж ангилна. Орон нутгийн татварт аймаг нийслэлийн ИТХ-аас хувь хэмжээг нь тогтоосон тухайн орон нутагт үйлчлэх татвар орно тухайлбал: ус, рашаан ашигласаны төлбөр гэжээ. Гэтэл усны тухай хуулинд зааснаар ус ашигласаны төлбөрийг Засгийн газар тогтоож байгаа учраас ус, усны төлбөрийг орон нутгийн бус улсын татварт оруулан тооцох хэрэгтэй байна. (үүний тулд татварын хуулийн 17-р зүйлээс усны төлбөрийг хасах шаардлагатай) Ийнхүү улсын татвар гэж тооцсоноор “**Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах хувь хэмжээний тухай**” хууль бүрэн хэрэгжих боломжтой болно. /
17. **Тухайн оны төсвийн тухай хууль** /Жил бүрийн төсвийн тухай хууль нь УХЭГ-ын төсвийн хэмжээг тогтоогоод зогсохгүй усны төлбөрт цугларуулах хөрөнгийн хэмжээг мөн тогтоож өгдөг. 2006 онд УХЭГ-ын Усны Хэмнэлтийн Төв нь 229,318,8 мянган төг улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөтэй болно./

**Усны Хэрэг Эрхлэх Газрын үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэглэгдэх зарим хууль тогтоомжуудын агуулга, онцлогийг тусгасан товч танилцуулга**

1. Үндсэн хууль
2. Засгийн газрын тухай
3. УИХ-ын тухай хууль
4. Хилийн тухай
5. Агаарын тухай
6. Ойн тухай
7. Байгалийн ургамлын тухай
8. Химийн хорт бодисоос хамгаалах тухай
9. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай
10. Төрийн нууцын тухай
11. Хувь хүний нууцын тухай
12. Байгууллагын нууцын тухай
13. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласаны төлбөрийн тухай
14. Байгалийн ургамал ашигласаны төлбөрийн тухай
15. Агнуурын нөөц ашигласаны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай
16. Ургамал хамгааллын тухай
17. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
18. Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай
19. Ашигт малтмалын тухай
20. Геодези, зураг зүйн тухай
21. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай
22. Амьтны аймгийн тухай, ан агнуурын тухай
23. Нягтлан бодох бүртгэлийн тухай
24. Газрын тухай
25. Төрийн албаны тухай
26. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай
27. Төрийн хяналт, шалгалтын тухай
28. Төрийн аудитын тухай
29. Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай
30. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай
31. Тариалангийн тухай
32. Засгийн газрын тусгай сангийн тухай

**Дөрөв.**

**Монгол улсад хэрэгжиж буй**

**үндэсний хөтөлбөрүүд**

1. Монгол улсын XXI зууны тогтвортой Хөгжлийн хөтөлбөр
1. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр
1. Усны үндэсний хөтөлбөр
1. Агаарыг хамгаалах хөтөлбөр
1. Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр
1. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр
1. Ойн тухай үндэсний хөтөлбөр
1. Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр
1. Чанарын болон Байгаль орчны удирдлага /менежмент/-ыг дэмжих үндэсний хөтөлбөр
1. Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарыг 2015 он хүртлэх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөр
1. Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр
1. Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр
1. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр